



## ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 5/03

Улаанбаатар хот

### Б.Гантулгад сахилгын шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 48.1.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсэг, 131.1.2 дахь заалт, Оюуны өмчийн газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/75 тоот тушаалаар батлагдсан Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Захиргаа удирдлагын хэлтсийн Нярав Б.Гантулга нь 2019 оны жилийн тайлан, 2020 оны нэг, дөрөвдүгээр улирлын төлөвлөгөөг боловсруулж, нэгжийн даргаар батлуулаагүй, байгууллагын 2020 оны үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогод бэлтгээгүй, 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01 дугаартай зөвлөмжид заасан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгээгүй, санхүүгийн тайлан бүртгэлийн Асoulus программд 2018 оноос хойш ажиллаагүй, архивын ажлыг 2003 оноос хавсран гүйцэтгэх хугацаандаа зааврын дагуу байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлдээгүй, байнга хадгалах баримтыг төрийн архивд шилжүүлээгүй, хугацаа дууссан баримтыг устгах хэргийн акт үйлдэж устгалд оруулаагүй, архивд хүлээн авсан баримтууд нь стандартын шаардлага хангаагүй тул албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Тушаалыг нийт албан хаагчдад танилцуулж, арга хэмжээ авч ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА

Б.ЭНХСҮХ





ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР

ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХСҮХ ТАНАА  
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН НЯРАВ Б.ГАНТУЛГАД САХИЛГЫН  
ШИЙТГЭЛ НОГДУУЛАХ САНАЛ ГАРГАХ ТУХАЙ

2021 оны 01 сарын 25 өдөр

№ 2/01

Улаанбаатар хот

Тус газрын Захиргаа удирдлагын хэлтсийн Нярав Б.Гантулга нь ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ биелүүлээгүй, Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн байна. Үүнд:

1. 2019 оны жилийн тайлан, 2020 оны 1-р улирал, 4-р улирлын төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй, Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дахь хэсгийг зөрчсөн;
2. Байгууллагын 2020 оны үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогод бэлтгээгүй;
3. Тооллогын комиссоос санал ирүүлсний дагуу гаргасан 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01 дугаартай Зөвлөмжид заасан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэн тайлагнаагүй;
4. Санхүүгийн тайлан бүртгэлийн Асoulus программ дээр 2018 оноос хойш ажиллаагүй;

Мөн Нярав Б.Гантулга нь 2003 оноос Архивын ажлыг хавсран гүйцэтгэх хугацаандаа байгууллагын архивын байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлдэж батлуулаагүй, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлдээгүй, байнга хадгалах баримтыг дансны хамт төрийн архивд шилжүүлээгүй, хугацаа дууссан баримтын устгах хэргийн акт үйлдэж, устгалд оруулаагүй, архивд хүлээн авсан баримтууд нь стандартын шаардлага хангаагүй байсан.

Ажил хавсран гүйцэтгэх хугацаандаа архивын ажлыг зааврын дагуу хийж гүйцэтгээгүй улмаас байгууллагын архивын 1.087 хадгаламжийн нэгжид техник боловсруулалтын ажлыг хийж, дахин үдэж цэгцэлж, 6.295.000 төгрөгийг зарцуулсан.

Иймд дээрх шалтгаануудыг үндэслэн Нярав Б.Гантулгад үндсэн цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулах саналтай байна.

Холбогдох баримтуудыг хавсаргав.

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

С.ГАНЗОРИГ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР

Зөвлөмж хүргүүлэх тухай

2020 оны 12 дугаар сарын 16

№ 01

Улаанбаатар хот

Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/213 дугаар тушаал гарсантай холбогдуулан тооллогын комисс хуралдаж нярав Б.Гантулгад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Хүн тус бүрийн картад шинэчлэл хийж, тооллогын комисст файлаар өгөх.
2. Бүртгэлгүй эд хөрөнгийн жагсаалтыг бүртгэлд оруулах.
3. Бараа материалын бүртгэлийн жагсаалтаас 00 үлдэгдэлтэй материалыг хасаж жагсаалтыг шинэчлэх.

Энэ зөвлөмжийг 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дотор хэрэгжүүлэн ажилласан байхыг мэдэгдье.

/12 цаг 00 минут/

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

ДАРГА

С.ГАНЗОРИГ

Хүргэвчсэн

2020.12.16 12:05



## ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР

### СОНСОХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭГДЭХ ХУУДАС

2021.01.08.

Дугаар 01

Улаанбаатар хот

Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, Оюуны өмчийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн нярав албан тушаалтай Б.Гантулга та цахим хэлбэрээр тус газрын able системийг ашиглан санал, тайлбараа бичгээр өгч сонсох ажиллагааг явуулах болсныг мэдэгдэв.

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.2, 48 дугаар зүйлийн 48.1.2 дэх хэсэг, Оюуны өмчийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/75 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 5.11 дэх хэсэг, мөн журмын 11.6.11 дэх хэсгийг тус тус үндэслэв.

Дараах асуудлаар санал тайлбараа бичгээр өгнө үү.

1. 2019 оны жилийн тайлан, 2020 оны 1-р улирал, 4-р улирлын төлөвлөгөө, тайланг гаргаагүй, , 2020 оны 1 дүгээр сард үндсэн эд хөрөнгийг кодолж бүртгэх ажлыг хийж гүйцэтгэхийг даалгасан боловч хийж гүйцэтгээгүй;
2. 2020 оны үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогод бэлтгээгүй;
3. Захиргаа удирдлагын хэлтсийн дарга С.Ганзоригоос 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01 дугаартай Тооллогын комиссоос гаргасан зөвлөмжид заасан хугацаанд тайлан, танилцуулга өгөөгүй;
4. Агуулахын бүртгэл албан ёсоор хөтлөөгүй;
5. Санхүүгийн тайлан бүртгэлийн Асoulus программ дээр 2018 оноос хойш 3 жилийн хугацаанд ажиллаагүй;

Дээрх 5 шалтгаанаар үндсэн цалинг 3 сарын хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах мэдэгдлийг гаргаж байна.

Хариу тайлбарыг Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.2, 27.4.5 дахь хэсгийг баримтлан цахим систем буюу /ABLE/ бичгээр Захиргаа удирдлагын хэлтсийн дарга С.Ганзоригийн able хаяг болон [ganzorig@ipom.mn](mailto:ganzorig@ipom.mn) гэсэн имэйл хаягаар 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 10.00 цагт ирүүлнэ үү.

Мэдэгдэх хуудсыг 2 хувь үйлдэв

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

 С.Ганзориг

Мэдэгдэх хуудас хүлээлгэн өгсөн:


Даргын туслах, бичиг хэрэг хариуцсан  
мэргэжилтэн



А.Бүжлхам

Огноо: 2021.01.08-ны 17 цагт 30 минут

Мэдэгдэх хуудас хүлээн авсан:

Нярав  Б.Гантулга

Огноо: 2021.01.08 -ны 17 цагт 37 минут

## СОНСОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛБАР

/2021 оны 1 дүгээр сарын 08 –ны өдрийн/

1. 2020 оны 4-р улирлын тайлан, 2021 оны төлөвлөгөөг бичсэн. Төлөвлөгөөнд зохих шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийнэ. Мөн 2021 оны 1-р улиралд багтаан эд хөрөнгийг коджуулах ажлыг гүйцэтгэнэ.
2. 2020 оны жилийн эцсийн тооллогод бэлтгэж үндсэн хөрөнгийн бүртгэлийг хүн тус бүр дээр бүртгэж, эд хөрөнгө ашиглалтын бүртгэлийг засаж бэлтгэсэн байсан. Бүртгэлд засвар хийх, нэмж бүртгэлжүүлэх тодоруулах ажил байсан болно.
3. Зөвлөмжид заасны дагуу ажилтан тус бүрийн эд хөрөнгийн картад засвар хийж тооллогын комисст 2021 оны 01-р сарын 19-ний өдрийн 16 цагт цаасаар хүргүүлсэн.
4. Агуулахын бүртгэлийг бүртгэж, тэмдэглэл хөтлөж эхэлсэн. Сонсох ажиллагааны мэдэгдэх хуудас ирэхээс өмнө агуулахын бүртгэл хөтлөөгүй байсан.
5. Санхүүгийн тайлан бүртгэлийн Acolous программыг заалгах гэсэн боловч тус программыг нийлүүлсэн компанитай холбогдож чадаагүй болно. /77775560/ 2021 оны 1 дүгээр улирлаас няравын тайланг Acolous программ дээр гаргах болно. Хэрэв заасан хугацаанд программ дээр шаарлага ханган ажиллаж чадахгүй бол хариуцлага хүлээнэ.

Тайлбар бичсэн нярав



Б.Гантулга

2021 оны 01 сарын 13